ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БУА-2022/110/НА-СТА-ТШЗ**


Аудитын газрын дарга,тэргүүлэх аудитор

Д.Анхбаяр:

Утас: 70342580 Цахим хаяг: Ankhbayard@audit.dov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг

2022 он

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn

Ахлах аудитор: П.Мөнхтуяа

Утас: 70342716 Цахим хаяг: Munkhtuyap@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

1. Аудитын санал дүгнэлт.....................................................................................3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл............................................5-15
3. Аудитын тайлан.....................................................................................15-18
   3.1 Ерөнхий зүйл.....................................................................................
   3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.........................................................
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал...............................................................
   3.4 Материаллаг байдал.....................................................................................
   3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга......................................................................
   3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.........................................................
   3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг...................................................
   3.8 Аудитын гол асуудал.....................................................................................
   3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.............
   3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт...........................................................................
   3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.................................................................
4. Аудитын илрүүлэлт.....................................................................................18-20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.............................................................20

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ЭМДС | Эрүүл мэндийн даатгалын сан |
| ЭМС | Эрүүл мэндийн сайд |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |

**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс:7034-3259
E-mail:bulgan@audit.gov.mn

2022.02.22 № 36

танай ______ ны № ______ т

АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ П.ОЮУНЦЭЦЭГ
ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

006020002

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **938,524,523.82** | **1,990,423,569.84** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 2,158,600.00 | 3,186,326.50 |
| **312** | **Банканд байгаа бэлэн мөнгө** | 2,158,600.00 | 3,186,326.50 |
| **3121** | **Төгрөг** | 2,158,600.00 | 3,186,326.50 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 00.00 | 581,326.50 |
| 31214 | Бусад төсөл, нөөцийн харилцах | 2,158,600.00 | 700,000.00 |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | 00.00 | 1,905,000.00 |
| **33** | **АВЛАГА** | 105,692.20 | 810,955,884.00 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 00.00 | 807,455,884.00 |
| **335** | **Бусад авлага** | 105,692.20 | 3,500,000.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 105,692.20 | 3,500,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 936,260,231.62 | 1,176,281,359.34 |
| **351** | **Түүхий эд материал** | 712,801,971.67 | 970,706,887.99 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 522,011,184.97 | 621,190,863.33 |
| 35130 | Эм боох материал | 190,790,786.70 | 349,516,024.66 |
| **354** | **Хангамжийн материал** | 223,458,259.95 | 205,574,471.35 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 4,335,006.40 | 4,108,736.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 10,696,313.10 | 8,376,922.90 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 55,000.00 | 00.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2,104,900.00 | 1,151,090.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 63,400.00 | 96,950.00 |
| 35460 | Хүнсний материал | 15,041,365.00 | 4,647,370.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 191,162,275.45 | 187,193,402.45 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **9,093,914,947.05** | **12,063,104,280.35** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 9,093,914,947.05 | 12,063,104,280.35 |
| **392** | **Биет хөрөнгө** | 8,834,900,780.49 | 11,847,698,447.15 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 5,755,757,492.57 | 5,755,757,492.57 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -126,272,212.81 | -359,905,016.53 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 474,553,219.64 | 499,553,219.64 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -147,888,088.21 | -243,785,847.13 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 4,813,443,782.24 | 9,147,586,720.52 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -2,329,730,460.26 | -3,315,729,907.23 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 515,671,573.70 | 567,927,914.41 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -170,984,955.44 | -249,944,499.80 |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 44,365,199.08 | 44,365,199.08 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -2,182,830.52 | -6,294,888.88 |

| | | | |
|---|---|---|---|
| 39217 | Ном | 5,168,060.50 | 5,168,060.50 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 259,014,166.56 | 215,405,833.20 |
| 39301 | Программ хангамж | 10,880,000.00 | 10,880,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -112,500.00 | -2,704,166.64 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 330,280,000.00 | 330,280,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -82,033,333.44 | -123,050,000.16 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **10,032,439,470.87** | **14,053,527,850.19** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **103,949,251.90** | **722,403,526.88** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 103,949,251.90 | 722,403,526.88 |
| **413** | **Өглөг** | 103,949,251.90 | 722,403,526.88 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 103,949,251.90 | 722,403,526.88 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **9,928,490,218.97** | **13,331,124,323.31** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 9,928,490,218.97 | 13,331,124,323.31 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 4,055,327,827.64 | 4,055,327,827.64 |
| 51101 | Өмч: - төрийн | 4,055,327,827.64 | 4,055,327,827.64 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 3,248,956,599.99 | 6,651,941,386.12 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 3,248,956,599.99 | 3,249,307,281.78 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 3,402,634,104.34 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,624,205,791.34 | 2,623,855,109.55 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **10,032,439,470.87** | **14,053,527,850.19** |

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **9,365,526,898.61** | **14,129,768,575.82** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,481,330,335.61** | **5,442,812,462.42** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 2,481,330,335.61 | 5,442,812,462.42 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 2,481,330,335.61 | 5,442,812,462.42 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 42,298,568.00 | 85,620,866.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 39,172,954.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **6,884,196,563.00** | **8,686,956,113.40** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 4,688,346,000.00 | 768,838,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 4,688,346,000.00 | 768,838,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 35,580,040.00 | 1,862,906,613.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 1,120,000.00 | 3,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 18,000,000.00 | 408,063,744.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 511,556,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 16,460,040.00 | 132,830,985.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | 00.00 | 807,455,884.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 00.00 | 340,000,000.00 |
| 133004 | Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт | 00.00 | 340,000,000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 2,160,270,523.00 | 5,715,211,300.40 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 2,160,270,523.00 | 5,715,211,300.40 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **7,709,596,903.75** | **10,727,134,471.48** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **7,709,596,903.75** | **10,727,134,471.48** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 7,704,638,399.32 | 10,365,770,571.48 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 4,281,633,389.50 | 4,635,474,911.40 |
| 210101 | Үндсэн цалин | 2,196,292,951.80 | 1,947,266,238.20 |
| 210102 | Нэмэгдэл | 1,631,699,949.76 | 2,251,699,389.20 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 150,051,000.00 | 144,762,000.00 |
| 210104 | Урамшуулал | 303,589,487.94 | 291,747,284.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 527,716,553.31 | 601,418,298.36 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 363,280,249.85 | 422,845,261.36 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 43,614,768.21 | 46,917,132.51 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 34,214,217.77 | 36,928,684.68 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 7,857,427.89 | 8,401,951.77 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 78,749,889.60 | 86,325,268.04 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 808,455,319.90 | 857,568,285.66 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 73,297,396.90 | 103,323,518.66 |
| 210302 | Түлш, халаалт | 597,836,278.00 | 617,223,453.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 137,321,645.00 | 137,021,314.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 119,881,149.62 | 130,191,684.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,512,765.80 | 9,008,878.40 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 45,464,109.00 | 55,851,540.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,983,879.32 | 8,289,855.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 59,424,435.50 | 56,575,460.60 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,495,960.00 | 465,950.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,133,499,337.97 | 2,544,231,637.61 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,006,463,362.97 | 2,332,210,729.61 |

| | | | |
|---|---|---|---|
| 210502 | Хоол, хүнс | 114,713,255.00 | 192,853,255.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 12,322,720.00 | 19,167,653.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 48,271,878.00 | 115,797,604.76 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 17,672,768.00 | 52,877,163.76 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 204,000.00 | 604,849.00 |
| 210604 | Урсгал засвар | 30,395,110.00 | 62,315,592.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 9,517,350.00 | 6,177,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,517,350.00 | 6,177,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 32,445,325.70 | 22,289,861.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 14,200,168.70 | 3,764,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,450,300.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 3,062,880.00 | 3,897,515.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 651,185.00 | 529,294.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 123,200.00 | 232,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 2,740,100.00 |
| 210807 | Газрын төлбөр | 495,400.00 | 495,420.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 27,040.00 | 71,100.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 11,435,152.00 | 10,559,432.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 743,218,095.32 | 1,452,620,788.69 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 271,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 743,218,095.32 | 1,452,349,288.69 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 4,958,504.43 | 361,363,900.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 4,920,000.00 | 361,363,900.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 00.00 | 251,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,920,000.00 | 110,363,900.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 38,504.43 | 00.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 38,504.43 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **1,655,929,994.86** | **3,402,634,104.34** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **1,655,929,994.86** | **3,402,634,104.34** |

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |

| | | | |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **6,977,088,468.30** | **7,965,121,095.40** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **81,823,492.00** | **85,620,866.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 81,823,492.00 | 85,620,866.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 81,823,492.00 | 85,620,866.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 42,298,568.00 | 85,620,866.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 39,524,924.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **6,895,264,976.30** | **7,879,500,229.40** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 4,688,346,000.00 | 768,838,220.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 4,688,346,000.00 | 768,838,220.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 46,648,453.30 | 1,055,450,729.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 1,120,000.00 | 3,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 18,000,000.00 | 408,063,744.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 511,556,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 27,528,453.30 | 132,830,985.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 00.00 | 340,000,000.00 |
| 133004 | Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт | 00.00 | 340,000,000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 2,160,270,523.00 | 5,715,211,280.40 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 2,160,270,523.00 | 5,715,211,280.40 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **6,914,852,267.30** | **7,937,407,868.90** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **6,914,852,267.30** | **7,937,407,868.90** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **6,909,893,762.87** | **7,576,043,968.90** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 4,282,111,051.71 | 4,635,320,219.20 |
| 210101 | Үндсэн цалин | 2,202,210,951.71 | 2,258,556,860.93 |
| 210102 | Нэмэгдэл | 1,582,888,700.00 | 1,899,116,537.27 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 173,943,000.00 | 144,744,000.00 |
| 210104 | Урамшуулал | 323,068,400.00 | 332,902,821.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 527,716,553.30 | 601,418,298.36 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 358,368,953.30 | 430,748,787.67 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 42,336,900.00 | 43,127,303.70 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 33,869,500.00 | 34,263,848.65 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 8,467,400.00 | 8,479,732.58 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 84,673,800.00 | 84,798,625.76 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 808,455,319.90 | 585,658,263.16 |

| | | | |
|---|---|---|---|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 73,297,396.90 | 103,323,518.66 |
| 210302 | Түлш, халаалт | 597,836,278.00 | 379,683,318.50 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 137,321,645.00 | 102,651,426.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 112,174,874.92 | 117,522,365.40 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,876,820.00 | 6,418,650.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 42,760,000.00 | 45,586,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,984,089.32 | 8,967,255.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 37,931,105.60 | 44,585,610.40 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 17,622,860.00 | 11,964,850.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,071,590,993.04 | 1,491,398,327.78 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 900,259,248.04 | 1,301,358,767.78 |
| 210502 | Хоол, хүнс | 124,862,645.00 | 181,820,760.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 46,469,100.00 | 8,218,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 64,273,930.00 | 102,285,966.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 20,284,100.00 | 30,368,344.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,510,000.00 | 1,044,700.00 |
| 210604 | Урсгал засвар | 42,479,830.00 | 70,872,922.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 9,517,350.00 | 6,177,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,517,350.00 | 6,177,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 34,053,690.00 | 29,747,129.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 13,006,645.00 | 4,907,900.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,450,300.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 3,062,880.00 | 3,897,515.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 651,185.00 | 529,294.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 123,200.00 | 232,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,576,000.00 | 9,021,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 495,400.00 | 495,420.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 47,040.00 | 71,100.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 11,641,040.00 | 10,592,400.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 00.00 | 6,515,900.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 6,515,900.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **4,958,504.43** | **361,363,900.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 4,920,000.00 | 361,363,900.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 00.00 | 251,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,920,000.00 | 110,363,900.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 38,504.43 | 00.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 38,504.43 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **62,236,201.00** | **27,713,226.50** |

| | | | |
|---|---|---|---|
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **68,992,201.00** | **26,685,500.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **68,992,201.00** | **26,685,500.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 68,992,201.00 | 26,685,500.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 68,992,201.00 | 26,685,500.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-68,992,201.00** | **-26,685,500.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | -6,756,000.00 | 1,027,726.50 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 8,894,600.00 | 2,158,600.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 2,158,600.00 | 3,186,326.50 |

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 3,725,047,827.64 | 2,649,271,122.13 | 603,999,806.10 | 00.00 | 6,978,318,755.87 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **3,725,047,827.64** | **2,649,271,122.13** | **603,999,806.10** | **00.00** | 6,978,318,755.87 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C08 | **2014 оны 12-р сарын 31-** | **4,055,327,827.64** | **2,624,205,791.34** | **3,248,956,599.99** | **00.00** | 9,928,490,218.97 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | **нээрх үлдэгдэл** | | | | | |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **4,055,327,827.64** | **2,624,205,791.34** | **3,248,956,599.99** | **00.00** | 9,928,490,218.97 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 350,681.79 | 00.00 | 350,681.79 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **4,055,327,827.64** | **2,624,205,791.34** | **3,249,307,281.78** | **00.00** | 9,928,840,900.76 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -350,681.79 | 00.00 | 00.00 | -350,681.79 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 3,402,634,104.34 | 00.00 | 3,402,634,104.34 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **4,055,327,827.64** | **2,623,855,109.55** | **6,651,941,386.12** | **00.00** | 13,331,124,323.31 |

ТГ

## ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 8,057,270,100.00 | 7,229,089,039.90 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 8,057,270,100.00 | 7,229,089,039.90 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 8,052,350,100.00 | 7,224,799,039.90 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 4,645,114,200.00 | 4,604,563,234.20 |
| 210101 | Үндсэн цалин | 2,235,429,100.00 | 2,227,799,875.93 |
| 210102 | Нэмэгдэл | 1,911,892,700.00 | 1,899,116,537.27 |

| | | | |
|---|---|---|---|
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 160,978,000.00 | 144,744,000.00 |
| 210104 | Урамшуулал | 336,814,400.00 | 332,902,821.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 605,265,100.00 | 597,476,371.36 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 434,517,500.00 | 426,806,860.67 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 42,686,900.00 | 43,127,303.70 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 34,149,500.00 | 34,263,848.65 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 8,537,400.00 | 8,479,732.58 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 85,373,800.00 | 84,798,625.76 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 910,760,700.00 | 585,658,263.16 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 103,399,100.00 | 103,323,518.66 |
| 210302 | Түлш, халаалт | 655,523,500.00 | 379,683,318.50 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 151,838,100.00 | 102,651,426.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 121,646,700.00 | 118,498,965.40 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,420,000.00 | 6,418,650.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 45,586,000.00 | 45,586,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 8,833,000.00 | 8,832,855.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 44,625,800.00 | 44,585,610.40 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 16,181,900.00 | 13,075,850.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,682,194,500.00 | 1,232,084,366.78 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,507,643,300.00 | 1,058,488,503.78 |
| 210502 | Хоол, хүнс | 165,451,200.00 | 165,377,063.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 9,100,000.00 | 8,218,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 45,292,300.00 | 44,956,010.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 18,604,100.00 | 18,267,900.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,044,700.00 | 1,044,700.00 |
| 210604 | Урсгал засвар | 25,643,500.00 | 25,643,410.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,500,000.00 | 6,177,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,500,000.00 | 6,177,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 29,276,600.00 | 29,167,029.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,929,500.00 | 3,927,900.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 3,897,500.00 | 3,897,515.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 529,300.00 | 529,294.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 232,500.00 | 232,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 9,430,000.00 | 9,420,900.00 |
| 210807 | Газрын төлбөр | 495,400.00 | 495,420.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 120,000.00 | 71,100.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 10,642,400.00 | 10,592,400.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 6300000.00 | 6217300.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,300,000.00 | 6,217,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 4920000.00 | 4290000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 4,920,000.00 | 4,290,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,920,000.00 | 4,290,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 8,057,270,100.00 | 7,229,670,366.40 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 768,838,200.00 | 768,838,220.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 768,838,200.00 | 768,838,220.00 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 7,202,870,000.00 | 5,715,211,280.40 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 7,202,870,000.00 | 5,715,211,280.40 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 85,561,900.00 | 85,620,866.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 85,561,900.00 | 85,620,866.00 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 581,326.50 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 251.00 | 251.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 190.00 | 195.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 60.00 | 55.00 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 00.00 | 00.00 |

НТ-2

## НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **733,545,729.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **733,545,729.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 376,771,829.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 30,756,985.00 |
| 210101 | Үндсэн цалин | 30,756,985.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 3,941,927.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 3,941,927.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 134,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 134,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 262,013,961.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 245,570,264.00 |
| 210502 | Хоол, хүнс | 16,443,697.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 78,944,556.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 33,715,044.00 |
| 210604 | Урсгал засвар | 45,229,512.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 980,000.00 |

| | | |
|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 980,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 356773900.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 356,773,900.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 251,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 105,773,900.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 735450729.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 735,450,729.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 3,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 88,063,744.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 511,556,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 132,830,985.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлан, бүртгэлд гарсан алдаа зөрчилтэй, холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитын газрын ахлах аудитор П.Мөнхтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь “Үйлчлүүлэгчийг эрхэмлэх, эерэг хандлагыг дээдэлж, чанартай аюулгүй лавлагаа, тусламж үйлчилгээг үзүүлнэ” гэсэн эрхэм зорилгыг тавьж ажилласны хүрээнд 5 зорилтыг хэрэгжүүлж ажиллахаар төлөвлөн ажилласан байна. Үүнд:

1. Үйлчлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдлыг сайжруулах
2. Сэргийлж болох халдварт болон ХБӨ-нөөс урьдчилан сэргийлэх үзлэг үйлчилгээ, НЭМ-ийн тусламжийг өргөжүүлэх
3. Гүйцэтгэлийн санхүүжилттэй тогтолцооны шинэ аргыг хэрэгжүүлэх
4. E-health программыг хөгжүүлж, цахимжуулалтыг сайжруулах
5. Хандлага, харилцааны үр дүнг урамшуулалтай холбон дүгнэх механизмыг бий болгох гэсэн зорилтуудыг хэрэгжүүлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар болон дотоод аудитын нэгжгүй болно.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

**3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 6194.8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 138.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 110.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Аймгийн “Нэгдсэн эмнэлэг” нь 2021 оны санхүүгийн тайлангийн тодруулгыг Сангийн сайдын 388 дугаар журмын 3-р хавсралтын дагуу бэлтгэж тайлагнасан байна. Үүнд: Санхүү байдлын, Үр дүнгийн, Мөнгөн гүйлгээний, Өмчийн өөрчлөлтийн тайлангууд, санхүүгийн тодруулга тайлангуудын өөрчлөлт, нягтлан бодох бүртгэлийн зарчмыг баримтлан, НБББ, санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүнгийн талаар болзошгүй өр төлбөр, авлагыг зэргийг тодруулж тайлагнасан болно.

**3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Нэгдсэн эмнэлэг нь 2021 онд улсын төсвөөс 768.8, ЭМДС-гаас 7202.9, үндсэн үйл ажиллагааны орлогоос 85.6 сая төгрөг буюу нийт 8057.3 сая төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөсөн байна.

**3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 2021 он улсын төсвөөс 768.8, ЭМДС-гаас 5715.2, нэмэлт дансаар 1055.4, орон нутгийн төсвөөс 340.0, үндсэн үйл ажиллагааны орлогоос 85.6 сая

төгрөг буюу нийт 7965.1 сая төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 7961.9 сая төгрөгийг зарцуулж 3.2 сая төгрөгийн үлдэгдэлтэйгээр тайлагнажээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэгдсэн эмнэлэг нь 2021 онд нэмэлт дансаар нийт 735.4 сая төгрөгийн санхүүжилт авснаас цалингийн зардалд 30.7, НДШ-д 3.9, эм эмнэлгийн хэрэгслийн зардалд 245.6, хоол, хүнсэнд 16.4, шуудан холбооны зардалд 0.1, багаж техник хэрэгсэлд 33.8, урсгал зардалд 45.2, тэтгэмжийн зардалд 356.8, бусад зардалд 1.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

**3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Ковид буюу цар тахалтай холбогдуулан тусламж үйлчилгээний орлого нийт 1721.8 сая төгрөгийн санхүүжилт авснаас ковидтой холбогдон гарсан зардалд 382.7 сая төгрөгийг нэмэлт дансаар зарцуулсан байна. Тухайлбал: Дархлаажуулалтанд 17.1, тандалтын зардалд 0.2, ажилчдын цалин, урамшуулалд 363.7, илүү цагт 1.6 сая төгрөгийг зарцуулж, ЭМС-ийн 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А/496, 2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А/585 тоот тушаалуудыг үндэслэн мөнгөн тэтгэмж урамшуулалд 354.4, улаан бүсэд ажилласан илүү цагийн нэмэгдэл цалинд 332.4, ковидын үед дуудагдаж ажилласан илүү цагийн нэмэгдэл цалинд 78.4 сая төгрөгийг тус тус олгожээ.

Хандив тусламжаар ковидтой холбогдуулж ЭМЯ-наас 3908.2, ОНБ-аас 152.6, ОНХС-гаас 318.1, иргэнээс 25.0 сая төгрөг буюу нийт 4403.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, эм, эмнэлгийн хэрэгслийн 859.0, тусгай зориулалтын 86.7, түлш шатахууны 9.3, бусад хангамжийн материалын 2.9, бичиг хэргийн 0.2, хүнсний 0.6 сая төгрөгийн орлого авч тус тус тайлагнажээ.

Санхүүгийн тодруулга тайланд оны эцэст авлага 81.1, өглөг 722.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнаж харилцагч байгууллагуудтай авлага, өглөгийн тооцоо нийлж ажиллажээ. Өмнөх жилээс авлагын үлдэгдэл 810.9, өглөгийг үлдэгдэл 618.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

**3.8 Аудитын гол асуудал**

Нэгдсэн эмнэлгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулж ажиллахдаа аудитын төлөвлөлтийн үе шатанд сонгосон нийт 13 эрсдэлийн хүрээнд горим сорилыг хэрэгжүүлэн ажиллалаа.

Хэрэгжүүлсэн горим сорилоор хандиваар олгосон үндсэн хөрөнгө, бараа материалын орлогыг бүрэн тусгаж ЭМС-ын 2021 оны А/496, А/585 дугаар тушаалаар олгогдсон мөнгөн тэтгэмжийг батлагдсан санхүүжилтийн дагуу олгосон ч 1.9 сая төгрөгийн тэтгэмжийг тушаал шийдвэргүйгээр болон жирэмсэн амаржсаны амралттай байгаа ажилчдад олгосон, мөн ковидын илүү цагаар олгосон нэмэгдэл цалингийн илүү цагийн бүртгэл, нэгтгэл бүртгэлтэй зөрүүтэй тайлагнагдсан, батлагдсан илүү цаг олгох шийдвэр болоод анхан шатны баримтын бүрдэл дутуу зөрчлүүд илэрсэнд холбогдох хууль журмын дагуу төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгч ажилласан.

**3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

**3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Үүний дагуу байгууллагын мэдээллийг шилэн дансанд бүрэн мэдээлсэн боловч 2021 оны "өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан", "аудитын тайлан дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан" мэдээг хугацаанд нь мэдээлээгүй, хоцроож мэдээлсэн байна.

**3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байгаа ч хугацаа хоцроож мэдээлсэн нь холбогдох шалгуурт нийцэхгүй байна.

**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар 4 зөвлөмж өгч ажилласнаас зөвлөмжийн хэрэгжилтийг тайланг 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 01/365 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Ажилчдын илүү цагийн бүртгэл, нэгтгэлтэй холбоотой анхан шатны баримтын бүртгэлийг архивлаж үдээгүй, цэгцгүй учраас анхаарал татахуйц байна. Иймд цалин, илүү цагийн нэмэгдлийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2.2 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 0.9 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 1.4 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгч ажиллалаа.

4.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа гараагүй болно.

4.2 Төлбөрийн акт

1. Тус нэгдсэн эмнэлэг нь 2021 онд ковид цар тахалтай холбогдуулан ЭМС-ын 2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А/585 тоот тушаалын дагуу олгох мөнгөн тэтгэмжийг жирэмсний амралттай байсан 2 ажилтанд 480000 төгрөгийн тэтгэмж олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", НББ-ийн тухай хуулийн 13.1. "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13 дугаар зүйлийн 6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", ЭМГ-ын 2021 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн 01/201 тоот зөвлөмж, хуулийн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүйд төлбөрийн акт бичлээ.

<u>Шийдвэрлэсэн нь:</u>
Төлбөрийн акт тогтоов.

2.Нэгдсэн эмнэлэг нь 2021 оны ковид цар тахалтай холбогдуулан ажилчдын 4, 5, 12 дугаар саруудын илүү цагийн бүртгэлийг баталсан нэгтгэл цагийн бүртгэлтэй тулгаж, илүү цагийн нэмэгдэл цалин олгосныг түүвэрлэн шалгахад илүү цагийн бүртгэл, нэгтгэл цагийн бүртгэлүүд зөрүүтэй бүртгэгдсэн, илүү, дутуу 1700707 төгрөгийг тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д "Анхан шатны

баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 6-д ”Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүйд төлбөрийн акт бичлээ.

Шийдвэрлэсэн нь:
Төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Тус эмнэлэг нь ковидын илүү цагийн бүртгэлийг батлуулж ажилласан ч зарим баталсан цагийн бүртгэлийн тооцоо дутуу, анхан шатны баримтын бүрдэл дутуу зөрчил илэрсэн нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.
Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж
Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Тэтгэмж урамшууллын зардалтай холбоотой асуудал***

*1.1. Илрүүлэлт:*

*Тушаал шийдвэргүйгээр 1.4 сая төгрөгийн мөнгөн тэтгэмж олгосон.*

*1.2. Өгсөн зөвлөмж:*

*Төсвийн тухай хуулийн 6.4.8, НББ-ийн тухай хуулийн 13.7 дахь заалтуудыг мөрдлөг болгож ажиллах.*

***2. Авлага өглөгийн зардалтай холбоотой асуудал***

*2.1 Илрүүлэлт:*

*Өмнөх оноос авлагыг 810.9, өглөгийг 618.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн.*

*2.2 Өгсөн зөвлөмж:*

*Өр авлагыг нэмэгдүүлж ажиллахгүй төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтыг баримталж ажиллах.*

***3. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал***

*3.1. Илрүүлэлт:*

*Шилэн дансанд мэдээлэх мэдээллүүдээс 2021 онд 2 мэдээ хоцроож мэдээлсэн байна.*

*3.2. Өгсөн зөвлөмж:*

*Шилэн дансанд мэдээлэх мэдээллийг цаг хугацаанд нь хоцроохгүй, хуулийн хугацаанд мэдээлж ажиллах.*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 02 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая/төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа зөрчлийн дүн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Нэгдсэн эмнэлэг | 6 | 4.5 | 0 | 0 | 2 | 2.2 | 1 | 0.9 | 3 | 1.4 |